



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/575

Номгон

Хяналт-үнэлгээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутагт дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны "Хяналт-үнэлгээ зохион байгуулах тухай" А/134 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулж буй сургалтын байгууллагад хяналт, үнэлгээ хийх ажлыг 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсугай.

2.Хяналт-үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Энхжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн дарга)

Гишүүд:


Э.Батцэцэг (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүн)

Ж.Дуламсүрэн (Ажил олгогч эздийн холбооны гүйцэтгэх захирал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүн)

3.Хяналт-үнэлгээг батлагдсан удирдамж, маягтын дагуу хугацаанд нь чанартай зохион байгуулж, ажлын тайланг 2023 оны 11 дүгээр сарын 05-ны дотор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд хүргүүлэхийг Ажлын хэсэг (Д.Энхжаргал)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642311487